

Сяньбичуудын бунхны ханын зургийн уран сайхны судалгаа (Шюй Шяньшю болон Лөү Рүй бунхны жишээн дээр)

Боржигины Хүчит ✉

Соёл урлагийн их сургуулийн Дүрслэх урлагийн академи, Улаанбаатар, Монгол Улс
✉ baohuqitu2020@126.com

Доржсүрэнгийн Уранчимэг

Соёл урлагийн их сургуулийн Дүрслэх урлагийн академи, Улаанбаатар, Монгол Улс

Ойдовын Хишигбат

Өвөр монголын Багшийн их сургуулийн Дүрслэх урлагийн академи,
Хөх хот, БНХАУ

Хураангуй: Шинэ зууны босгон дээр нүүдэлчдийн дүрслэх урлагийн түүхэнд холбогдох нэгэн маш чухал олдвор илэрсэн билээ. 2000 онд илэрсэн энэхүү бунхан нь өмнөх зууны 80-аад онд илрүүлэн судалсан Лөү Рүй бунхны ханын зургаас илүү бүрэн бүтэн хадгалагдан үлдсэн байна. Энэхүү олдвор нь одоогийн БНХАУ-ын Шаньси мужийн Тайюань хотын орчимд байгаа юм. Шюй Шяньшю болон Лөү Рүйн бунхны ханын зургууд нь нүүдэлчдийн уран зургийн арга техникийн шинэчлэлээр зогсохгүй, тухайн үеийн нийгмийн төрх байдал, үндэстнүүдийн харилцан нөлөөлөл, соёлын солилцооны гүн гүнзгий агуулгыг нэгэн цогцоор тусган харуулсан байдгаараа онцлог. Энэхүү судалгаагаар зохиомжийн онцлог, дүрслэлийн агуулга, арга барилын шинэчлэл гэсэн гурван үндсэн судалгааны чиглэлээр археологийн олдвор болоод бичгийн эх сурвалж дээр тулгуурлан дүн шинжилгээ хийснээр Сяньбичуудын бунхны ханын зургийн урлагийн онцлог, түүхэн үнэ цэнийг тодруулсан болно.

Түлхүүр үгс: Сяньби, бунхны ханын зураг, урлагийн онцлог, түүхэн үнэлэмж

Research on the Artistic Aesthetics of Murals in the Tombs of Xianbei Nobility (A Case Study of the Xu Xianxiu and Lou Rui Tombs)

Khuchit Borjigin ✉

Academy of Fine Arts, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia

✉ baohuqitu2020@126.com

Uranchimeg Dorjsuren

Academy of Fine Arts, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia

Khishigbat Oidov

Fine Arts Academy of Inner Mongolia Normal University, Hohhot, China

Abstract: At the dawn of the new century, a significant discovery was made related to the history of nomadic representational art. Unearthed in the year 2000, this tomb has been preserved more completely than the Lou Rui tomb murals discovered and studied in the 1980s. This find is located in the vicinity of present-day Taiyuan City, Shanxi Province, in the People's Republic of China. The tomb murals of Xu Xianxiu and Lou Rui are notable not only for their innovative techniques in nomadic painting but also for their comprehensive reflection of the social conditions of the era, the interactions among ethnic groups, and the profound content of cultural exchange. Through this research, which focuses on three main areas—compositional features, representational content, and methodological innovation—and is based on archaeological findings and written sources, the artistic characteristics and historical value of the Xianbei tomb murals have been clearly elucidated.

Keywords: *Xianbei, tomb murals, artistic characteristics, historical evaluation*

Оршил

Монголын дүрслэх урлагийн түүхэнд ханын зураг нь онцгой чухал бүрэлдэхүүн хэсгийн нэг болсоор иржээ. Ялангуяа Сяньбийн үеийн бунхны ханын зураг нь урлагийн түүхнээ гэрэл гэгээтэй хөгжлийн үеийг бэлгэдэн харуулдаг. “Хүннү улс мөхсөний дараа Сяньби нар төр улсаа байгуулжээ. Модун шаньюйн үеэс эхлэн одоогийн Монгол Улсын нутгийн зүүн хэсэг, Өвөр монголын Зуу-удын чуулганы Шар мөрний сав газраар нутаглаж байгаад сүүлд улсаа байгуулан Монгол Улсын нутгийн зарим хэсгээр тархан нутагласан ажээ” (Гэрэлбадрах 2002, 27). V-VI зууны үед хүрээлэн буй орчин, соёлын хөгжлийн нөлөөгөөр бүрэлдсэн энэхүү гайхамшигт бүтээлүүдийн дотроос Шюй Шяньшю, Лөү Рүй хоёр бунхны ханын зураг онцгойрон ялгардаг.

Эдгээр бунхны ханын зургууд нь тухайн үеийн Сяньби угсаатны амьдрал, соёл, шашин шүтлэг, нийгмийн бүтцийг тод томруун гэрэлтүүлэн харуулаад зогсохгүй, уран сайхны илэрхийллийн өвөрмөц хэв маягийг бий болгосон байдаг. Эдгээр дүрслэлд Сяньбийн нүүдлийн соёл иргэншлийн онцлог, байгальтай харьцах өвөрмөц харилцаа, мөн тухайн үеийн гоо зүйн үзэл хандлага гүн гүнзгий

илэрсэн байдаг. Одоогийн БНХАУ-ын умард нутагт илэрсэн эдгээр бунхны ханын зургуудыг судлах нь зөвхөн Сяньби угсаатны урлагийн хэв маягийг ойлгоход төдийгүй, түүхэн соёлын урсгалыг нээн тодруулахад чухал түлхэц болсоор байна. Эдгээр уран бүтээлийг нарийвчлан судалснаар бид эртний Монгол нутагт хөгжсөн дүрслэх урлагийн гарал үүсэл, хөгжлийн замнал, гоо зүйн үнэт зүйлсийг илүү бүрэн дүүрэн тодруулан ойлгох боломжтой юм.

Судалгааны арга зүй

Сяньбичуудын бунхны ханын зургийн уран сайхны судалгаанд эх сурвалжийн задлан шинжилгээ, бунхны ханын зургийн хүний дүрслэл ба түүний агуулгыг тайлбарлахад ажиглалт, герменевтик тайлбарлал, иконографи, иконологи, тэмдэг зүй, өнгөний хэрэглээ дүр төрхийн онцлогийг тодорхойлохын тулд харьцуулалт, задлан шинжилгээ, нэгтгэн дүгнэх арга зүйг хослуулан хэрэглэв.

Судалгааны үр дүн

Нүүдэлчдийн бунхны ханын зураг нь газар зүйн байршлын хувьд голчлон өмнөд бүсэд төвлөрсөн байдаг онцлогтой. Эдгээр бунхны ханын зураг нь Сяньбийн соёл, хятад соёл, буддын урлаг гэсэн гурван соёлын уялдаа холбоог тодорхой илтгэхээс гадна, зурж эхлэх, өнгө тавих явцдаа бүдгэрүүлэх, зураас татах зэрэг олон төрлийн арга барилыг багтаасан дүрслэлийн тогтолцоогоороо (системээрээ) тухайн үеийн олон соёлын харилцан үйлчлэлийн үйл явцыг тодорхой илтгэн харуулдаг. Олон улсын түвшинд хийгдсэн судалгаануудад тулгуурлан судлахад Лөү Рүй болон Шюй Шяньшю ханын зурагтай бунхнууд нь зөвхөн Сяньбийн угсаатны өв соёлын үнэт дурсгал төдийгүй, тэдний нийгмийн бүтэц, соёл, ёс заншлын зан үйлтэй салшгүй холбоотой дэлхий дахины сонгодог урлагийн өв хэмээн үнэлэгдэх ёстойг олон талаар батлан харуулдаг. Ялангуяа монголын дүрслэх урлагийн түүхэн хөгжилд чухал хувь нэмэр оруулж буй урлагийн түүхэн дурсгал юм.

Зохиомжийн онцлог

Дүрслэх урлагийн нэгэн төрөл жанр болох ханын зураг нь зохиомжийн шийдлээрээ бусдаас илүү тод ялгардаг. Тэр ч утгаараа “Сүрлэг (монументаль) уран зургийн нэг төрөлд тооцогддог. Байшин барилгын хана, туурганд зурсан сүрлэг (монументаль) уран зураг” (Батчулуун 2018, 755) хэмээн монголын дүрслэх урлагийн нэвтэрхий тольд тэмдэглэсэн байдаг. Нүүдэлчид эртнээс орд өргөө, булш бунхан, сүм хийдийн хана туурганд зурж ирсэн уламжлалтай.

Сяньбичуудын бунхны ханын зургуудын зохиомж нь Хань, Вэй улсын үеэс уламжилсан баганаар хуваах уламжлалт арга барилаас давж, бүтэн орон зайн уялдаа холбоог эрэлхийлсэн онцгой арга барилтай байдаг гэж судлаачид үздэг. Шюй Шяньшю бунхны ханын зургийг авч үзвэл “нэг төвт” толин буулгалтын аргаар голлон зохиомжилсон байна. Жишээ нь, бунхны умард ханан дээрх найр цэнгээний зургаар төв болгож, зүүн болон баруун хананд маш олон үйл явдлыг тоочилтын аргаар эрэмбэлэн байрлуулжээ. Хэдийгээр агуулга нь өөр өөр ханан дээр зурагдсан боловч жагсаалын үргэлжлэл ба чиглэлийн нарийн төлөвлөлтөөр дамжуулан, бунхны эзний сүнс газрын амьдралаас мөнхийн орон зай руу шилжих хөдөлгөөнт үйл явцыг бүрэн дүүрэн дүрслэн харуулжээ. Үүнд, өнгөт зургуудыг

судалгааны эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан харуулсан бол зураасан зургийг бидний зүгээс судалгааны явцад анх гардан гүйцэтгэв (Зураг 1, б).

Бунхнаас олдсон хамгийн чухал илрүүлэлт бол 300 гаруй ам дөрвөлжин метр талбай бүхий ханын зураг юм. Нийтдээ 200 гаруй хүн, долоон морь, нэг үхэр тэрэг, найман шүтээн амьтан зэрэг дүр дүрслэл бүртгэгдсэн. Мөн цэрэг дайчдын төрөл бүрийн зэвсэг хэрэгсэл, хөгжмийн зэмсэг, ахуй амьдралын өдөр тутмын хэрэглээний эд зүйлс, чимэглэлийн хээ угалзууд багтана. Бунхны хонгилын хоёр талд 96 хүн, зургаан морь, дөрвөн сахиулсан амьтнаас бүрдсэн асар том хэмжээний ёслолын бүрэлдэхүүний эгнээ, эрэмбэ дараалал дүрслэгдсэн байдаг.

Ханын зурагт дүрсэлсэн хүмүүсийн хэмжээ бодит хүнтэй ойролцоо бөгөөд хамгийн өндөр нь 1.77 метр, хамгийн намхан нь 1.42 метр юм. Зүүн, баруун хананд байрлах зураг нь тэгш хэмтэй бөгөөд нийт 86 хүн, дөрвөн шүтээн амьтныг дүрсэлсэн байна.

Лөү Рүй бунхны ханын зургийн зохиомж нь Шюй Шяньшю бунхны ханын зургийн зохиомжоос ихээхэн өөр юм. Гурван давхар шаталсан бүтэцтэй байдаг. Дунд давхаргад нь аравтаар нэгж болгосон морьт цэргийн эгнээг зурсан байна. Бунхны хонгилын ханын зургуудыг гурван давхаргаар хуваан зохиомжлохдоо аян замд мордож байгаа болон харьж ирж байгаа үйл явдлыг цаг хугацааны эхлэл, хөгжил, өрнөл, төгсгөлөөр дараалуулан тоочих аргаар өгүүлжээ. Баруун ханын дээд давхаргын захад орших гурвалжин орон зайг нэн урнаар ухаалаг шийдсэн нь сонирхолтой ажээ. Жишээлбэл, бусад том дүрс зурах боложгүй тэрхүү хурц өнцөг бүхий орон зайд гүйж буй нохойг зохиомждоо ашигласан нь бүх зургийн дунд орших хөдөлгөөн, хэмнэлийг улам бүр нэмэгдүүлсэн байна (Зураг 2, б).

Лөү Рүй бунхны ханын зургийг агуулгаар нь 71 хэсэгт ангилан үзэж болох болохтой байна. Зураг зурсан нийт талбай нь 220 ам дөрвөлжин метр юм. Эдгээр зургийн агуулгыг ерөнхийдөө хоёр том бүлэгт хувааж болно.

Эхний бүлэгт нь Лөү Рүй жанжны амьд сэрүүн байх үеийн морины нуруун дээрх цог золбоот амьдрал болон амьдралынх нь төр улсын хэрэгт зүтгэсэн алдар хүндийг илтгэн харуулсан байна. Үүнд, алс аян замд мордож буй, харьж ирж буй морин цэргийн харуул, ордны амьдралын дүр зураг зэрэг багтана. Эдгээр нь бунхны хонгилын зүүн баруун хананд байрлах бөгөөд бунхны эзэн Лөү Рүйгийн амьдарч байх үеийн нөлөө бүхий баян тансаг амьдралыг дүрслэн харуулсан байна.

Хоёрдугаар бүлэгт, бунхны эзний нас нөгчин тэнгэрт хальснаар тэнгэрийн орны амьдралын жаргалант байдлыг дүрслэн харуулжээ. Үүнд өлзий бэлэгт дохио тэмдгүүд, тэнгэрт гарах үеийн зураглал орно.

Энэхүү ханын зураг нь БНХАУ-ын хилээс хэзээ ч үл гаргах нэн үнэт өвөөр бүртгэгдсэн байдаг. Энэ нь тус судлагдахууны үнэ цэн нь ямар түвшинд болохыг улам бүр баттай харуулж байна. Бунхны зүүн хананы өнгөт зургуудыг судалгааны эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан харуулсан бол, зураасан зургийг бидний зүгээс энэхүү судалгааны явцад анх гардан гүйцэтгэв.

Тус хоёр бунхны нийтлэг онцлог нь хуйлмал зургийг санагдуулам тооцолтын зохиомж ашиглан олон үйл явдлыг нэгэн дор нэгтгэж, “тэнгэр ба газар” гэсэн томоохон орон зайг нэгэн дор бүтээсэн явдал бөгөөд Сяньбийн үеийн зураачид бүхэл цогцын орон зайд суурилсан өгүүлэмжийг эрэлхийлж эхэлснийг нотлон харуулдаг.

Дүрслэлийн агуулга

Сяньбичуудын бунхны ханын зургуудын агуулга нь бунхны эзний амьд сэрүүн ахуйн тансаг амьдрал болон нас барсны дараах тэнгэрийн оронд хүрэх хүсэл тэмүүллийг төв болгож, бодит дүрслэл ба бэлгэдлийн утгыг хослуулсан байдаг.

А. Ердийн амьдралын тухай дүрслэл

Сяньбичуудын ханын зураг нь тухайн үеийн нийгмийн бүтэц, соёлын зан үйл болон угсаатны нэгдлийг судлах үнэтэй дурсгал юм. Ийм сэдвүүд ихэвчлэн Зүүн Вэй-ээс умард хятадын түрүү үе хүртэлх хугацаанд орших ханын зургуудад нийтлэг тохиолддог бөгөөд хувцас хэрэглэл, хүнс тэжээл, орон байр, хөдөлмөр, найр цэнгэл, ан ав зэрэг олон талт амьдралын дүр төрхийг илэрхийлсэн бөгөөд энэ нь Сяньби үндэстэн нүүдэлчдийн соёлоос газар тариалангийн тогтмол суурьшмал амьдралд шилжсэн нийгмийн өөрчлөлтийг харуулдаг.

БНХАУ-ын судлаач Сунь Үжүнь “Умард төр Сүй Тан улсын үеийн Хятад руу нүүн ирсэн Согдчуудын бунхны ханын зургийн дүрслэлийн соёл, гоо зүйн судалгаа” гэх нэгэн сэдэвт бүтээлдээ зүүн Вэй, баруун Вэй, умард Чи болон умард Жөү улсын үеийн бунхны ханын зургийн ан агнуурын дүрслэлүүдийг харьцуулан шинжилсний үр дүнд, энэ үеийн ан агнуурын эдийн засгийн ач холбогдол буурч, нийгмийн үүрэг нь нэмэгдсэн бөгөөд эцэстээ дээд давхаргын жаргал цэнгэл, зугаалгын үйл ажиллагаа болон хувирсан гэдгийг ханын зургийн дүрслэлүүдэд тодорхой харж болно (Сунь Ужүнь 2012) гэсэн дүгнэлт гаргасан байдаг.

Шюй Шяньшю бунхны хойд ханын “найр цэнгээний зураг” бол ердийн амьдралын тод төлөөлөл юм. Бунхны эзэн хаан хөшигний дор эрхэмсгээр заларч, хатан нь аяга барьж, хөгжимчид хөгжимдөж буй дүрслэл харагдана. Сувдан хээт хувцасны нарийн чимэглэлүүд нь Сяньби язгууртны тансаг амьдралыг нарийвчлан харуулдаг. Харин явган болон морин цэргийн цувааг харуулсан зурагт морьдын тоног, гоёмсог эмээл, цацар татуулсан үхэр тэрэгнүүд болон 86 хүний бүрэлдэхүүнтэй сүрлэг жагсаал дүрслэгдсэн нь Сяньбичуудын дээд албан мяндагтны сүр хүчийг тод томруун илэрхийлжээ. Лөү Рүй бунхны зүүн ханын “морьт анчдын зураг” нь морьтон ба хүний эрчимт хөдөлгөөний дүрслэлээр Сяньби язгууртны ан ав болон цэргийн сүр хүчийг харуулсан байдаг (Зураг 3, а, б)

Б. Мөнхийн оршихуйн тухай дүрслэл

Бунхны ханын зураг дахь домгийн бэлгэдэлт амьтад, тэнгэрийн орны дүрслэл ба ёслолын хэсгийн дүрслэлийн зураг нь бунхны эзний сүнс мөнхийн орон зайд одохыг илтгэн харуулдаг. БНХАУ-ын эрдэмтэн судлаач Жэн Янь “Нас барсан хүмүүсийн маск-Хань, Тан улсын үеийн бунхны урлагийн судалгаанд Хань улсын үед нас барсан хүмүүсийн ертөнц нь амьд ахуй үеийн ертөнцтэй нь төстэй байдаг хэмээн үздэг байсан ба үүнийг урлагийн бүтээлээр бүрэн илэрхийлэн харуулдаг байв. Ийм ойлголт нь урлагийн орон зайн шинэ хөгжлийг нээсэн бөгөөд бунхан нь урлагийн шинэ орон зайн илэрхийлэл болсон гэж үзжээ” (Жэн Янь 2013, 320). Энэ үеийн ханын зургийн өндөр хөгжилтөд хүрсэн талаар задлан судлахад энхүү үзэл хандлагыг дэмжүүштэй.

БНХАУ-ын судлаач Ү Хун “Мөнх бусын орны урлаг-Хятадын эртний бунхны өргөн хүрээний судалгаа” бүтээлдээ “Оршуулгын үеэр бунхны гол хэсгийг битүүмжлэх боловч үүд болон хонгилыг нээлттэй үлдээснээр, дараах үеийн гэр

бүлийн гишүүдэд нэмэлт оршуулга хийх боломж олгодог. Энэхүү бунхны загвар нь зөвхөн үхэлд бэлдэх ёс заншлыг илтгэхээс гадна, газар доорх амьдралын тухай уран сэтгэмжийг төлөвшүүлж, улмаар эртний бунханд нэвтэрсэн хүмүүсийн тухай олон домог, уран зохиол бий болгоход нөлөөлсөн”(Ү Хун 2010, 120-135) гэж тэмдэглэсэн байна. Шюй Шяньшоу бунхны хаалганы дээгүүр бунхныг хамгаалагч сүрдэм дүр дүрслэлтэй аймшигт араатан зурж, туурганд нь одод ба цэцгэн хээтэй лянхуа дүрслэлээр тэнгэрийн орныг бэлгэдэн бүтээсэн байна. Мөн бунхны үүдний хонгил дахь жагсаалын үргэлжлэл нь “булаг мэт ундрэн үргэлжилнэ” гэсэн далд утгыг илэрхийлдэг. Лөү Рүй бунхны тааз болон хонгилын ханан дээр хөх луу, цагаан бар, арван хоёр жилийг дүрслэн бүтээсэн нь амьдрал ба мөнх бусын ертөнцийг харьцуулан урлажээ.

Шашны бэлгэдэл дахь ногоон өнгөний утга бэлгэдэл: Бунхны туурган дээрх тэнгэрийн орны зурагт дийлэнхдээ номин өнгийг хэрэглэгсэн нь буддын шашны цэвэр ариун орон болон Бумбын шашны мөнхийн оршихуйн санааг хослуулан илэрхийлсэн байна. Жишээ нь, Шюй Шяньшоу бунхны туурган дахь лянхуа цэцгийн хээг цэнхэр ногооноор будсан нь Сяньбичуудын төрийн сүүл үеийн “Буддизм, Даосизм хоёрын хамтын шүтлэг”-ийг тусгасан байна гэж үзэж болох талтай.

Арга барилын шинэчлэл

А. Ур чадварын шинэчлэл

Ханын зураг дахь хүний хувцас, чимэглэлээс Сяньби соёл ба баруун хязгаар соёлын уялдаа тодорхой харагддаг. Тухайлбал, Шюй Шяньшоу бунхны ханын зургууд дахь хүмүүсийн дугуй захтай нарийн ханцуйтай дээл, сувдан хээт эмээл тоног, хөгжмийн зэмсэг болон босоо гүдгэр хөгжмийн дүрслэл зэрэг нь умард Чи улс Торгоны замаар дамжуулан Төв Ази, баруун Азитай соёлын харилцаа тогтоосныг гэрчилдэг. Мөн Лөү Рүйн бунхны ханын зургууд дахь хүмүүсийн өндгөн хэлбэрийн нүүр, өндөр хамар, гүн хонхор нүд зэрэг шинж тэмдэг нь Сяньби үндэстний гоо зүйн чиг хандлагыг тусгасан байна.

Баруун хязгаар орны соёлын нөлөө: Торгоны зам Хань, Вэй улсын үеэс эхлэн нээгдсэнээр гадаад орнуудтай арилжаа худалдаа, бэлэг солилцоо эрчимжиж, бусад үндэстнүүдтэй ч мөн харилцаа улам гүнзгийрсэн байна. Сяньбичуудын урлаг Төв Ази, баруун Ази, өмнөд Азийн соёлын нөлөөнд автсан бөгөөд тэр дундаа Персийн урлагийн сувдан хээ онцгой тод илэрдэг. Сувдан хээт торгоор хийсэн чимэглэл нь бунхны ханын зургууд дээр голдуу хувцасны зах, ханцуй, банзал зэргийн хөвөөг чимэглэхэд хэрэглэгдсэн байна. Шюй Шяньшоу бунхны зурагт зөвхөн ийм маягаар хэрэглэсэн жишээг олж харж болно. Тан улсын Ли Яньшоугийн “Умард Төрийн түүх”-ийн 97-р ботийн “Баруун хязгаарын тэмдэглэл”-д дурдсанаар “Эрчүүд үсээ тайрч, торгон дээл өмсөнө. ...Хүн бүр өндөр хамартай, гүн хонхор нүдтэй, өтгөн сахалтай” (Ли Яньшөү 1974, 3234) гэжээ. Шюй Шяньшоу бунхны ханын зургуудад энэ төрлийн дүр төрхтэй хүмүүс гарч байгаа нь тэдгээр нь хятад гаралтай биш, харин баруун орноос ирсэн угсаатан болохыг харуулдаг. Эдгээр хүмүүсийг магадгүй Согд гаралтай гэж үздэг. Шюй Шяньшоу бунхны зүүн хананд дүрслэгдсэн зарц шивэгчдийн дунд буржгар үс бүхий шивэгчин байх бөгөөд олдворлогчид энэ үсийг буржгар хиймэл үс, эсвэл тухайн үеийн үсний хэв маяг гэж үзжээ. Энэ

төрлийн буржгар үс нь мөн л баруун хязгаарын соёлын нөлөөний үр дүн болох нь тодорхой юм.

Б. Материалын шинэчлэл

Өнгийн онол, түүний мөн чанарыг тайлбарлах үндэс суурь эрт үеэс эхэлсэн байдаг. “Эртний Грек гүн ухаантнууд гэрэл, өнгө, агаар, орчны шүтэлцээнд юмсын зүс хувьсан өөрчлөгдөж, зохицох үзэгдлийг тайлбарлаж, шастир зохиолдоо бичиж тэмдэглэж үлдээжээ. Тухайлбал, НТӨ 300 жилийн тэртээд эртний грекийн философич Аристотель (НТӨ 384-322 он) “Өнгө бол энгийн нийлмэл зүйл биш. Нүд ба ямар нэг эд зүйлсийн хооронд байх тэр тунгалаг орчин агаар их чухал нөлөөтэй” гэсэн байна (Батсайхан 2017, 14).

“Улаан хүрэн өнгө нь хүн төрөлхтний хамгийн эрт хэрэглэж байсан өнгөнүүдийн нэг бөгөөд эртний уран зурагт маш түгээмэл байсан өнгө юм. Энэ нь хүмүүсийн анхлан хэрэглээнд нэвтэрсэн будагнаас үүдэлтэй аж. Дэлхийн өнцөг булан бүрд үлдсэн түүхэн өмнөх үеийн уран зургуудад улаан хүрэн өнгийн ул мөрийг олж харж болно” (Лю Юэ 2024, 2). “Улаан, улбар шар, шар өнгүүд нь өнгөний аймаг дахь баатар эрс мэт байж, эрч хүч, баян тансгийг бэлгэддэг бол энэ бүл өнгөнөөс улаан өнгө нь хамгийн хүчтэй, сэтгэл зүйд цочрол өгдөг өнгө юм. Улаан өнгө нь цаг ямагт хүсэл тэмүүлэл, эрсдэл, уриалан дуудсан шинж чанарыг агуулдаг” (Батсайхан 2020, 184) гэсэн тайбар нь энд дурдагдаж байгаа ханын зургуудын өнгөний хэрэглээгээр батлагдаж байна.

Сяньбичуудын бунхны ханын зургуудын өнгөний хэрэглээ нь “авсаархан мөртөө баримжаа гоо сайхан”-ыг онцолж, бодит дүрслэл ба гоёл чимэглэлийн шинж чанарыг хослуулсан байдаг. Сяньбичуудын зураачид баруун хязгаарын “Биетээр харагдах арга”-ыг өөр болгож, хүний нүүр царайд “тэгшхэн газрыг будаж, гүдгэрийг нь орхих” буюу уусган бүдгэрүүлэх аргыг хэрэглэжээ.

БНХАУ-ын эрдэмтэн Лүө Шипин “Шюй Шяньшю бунхны ханын зургууд дахь уусгалт ба Шиньжянгийн Чюзыгийн агуйн ханын зургуудын дүрслэлийн аргыг харьцуулсан судалгаандаа, эдгээрт ижил төстэй байдал тодорхой ажиглагддаг гэж үзжээ. Баруун хязгаараас дамжин ирсэн буддын шашны Гандхара урлаг Сяньбийн үеийн зурагт уран сайхны арга барилд бодит нөлөө үзүүлсэн хэмээн дүгнэжээ” (Лүө Шипин 2004, 224).

Байгалийн холбоо: Өнгөний ихэнх нь байгалийн гаралтай улаан хад, хөх чулуу, цагаан шавар бөгөөд тэдгээр нь тэнгэр, газар, галыг бэлгэддэг гэж бас үздэг. Шюй Шяньшю бунхны зургийг жишээ болгон авч үзвэл, нүдний хонхор, амны булан зэрэг нам дор хэсгийг улбар шар өнгөөр бүдгэрүүлэн будаж, харин хамрын уг, хацрын гүдгэр хэсгийг цайвар орхиж, улмаар гурван хэмжээст байдлыг бий болгожээ. Энэ арга барил нь зарим талаар дүрмийн шинжтэй боловч уламжлалт жигд өнгө оруулах аргаас даван гарч, Сүй ба Тан улсын үеийн бодитойгоор зурах аргын үндэс суурийг тавьжээ.

VI зууны дунд үеийн зурагт “Барууны хэв маяг” хэмээх нэгэн онцлог төрлийн зураглал дэлгэрсэн нь БНХАУ-ын уламжлалт уран зургаас ялгаатай байв. Энэхүү арга нь хуш модны самрын тосыг холигч болгон хэрэглэдэг бөгөөд европын тосон будгийн зургийн техниктэй төстэй юм. 2016 онд БНХАУ-ын эрдэмтэн судлаач Ван Ванфу нар умард Чи улсын Шюй Шяньшю бунхны ханын зургийн

хамгаалалт, сэргээн засварлах судалгаандаа Шюй Шяньшю бунхны ханын зургууд дахь нэгэн төрлийн өнгөний зохицол, баялаг өнгөний илэрхийлэл, хүний нүүрний тод уусгалт зэрэг нь баруун орноос нэвтэрсэн “Барууны хэв маяг” болон баруун орны зураглалын арга барил, үзэл санаа Сяньби уран зурагт бодитой нөлөөлснийг нотолж байна. Эдгээр гадаадын уран сайхны элементүүд нь тухайн үеийн шинэ зургийн хэв маягийг бүрэлдэн бий болоход чухал хөшүүрэг болж, “Баруун орны соёлын нөлөөний” онцлогийг илэрхийлсэн шинэ дүр төрхийг бий болов гэж үзжээ (Ван Ванфу 2016, 12).

Шюй Шяньшю бунхны ханын зургууд дахь хуш, самрын тосны техник нь гол төлөв түүний зургийн материал ба арга барилд туссан байдаг. Хуш, самрын тосоор өнгийг зуурч хэрэглэх арга нь VI зууны дунд үеийн зурагт өргөн дэлгэр хэрэглэгдэж байв. Гол онцлог нь дараах байдалтай байна. Үүнд, өнгөний зохицолд хуш самрын тосыг будгийн найрлагад ашигласнаар өнгө илүү жигд, тод гардаг. Мөн хуш самрын тос нь чийгээс хамгаалах, хөгц мөөгөнцрөөс сэргийлэх шинж чанартай тул ханын зургуудыг урт хугацаанд хамгаалахад тус болдог. Зураглалын үр нөлөөнд, хуш самрын тосоор зуурсан будгаар зурсан ханын зургуудын өнгө удаан хадгалагдаж, амархан бүдгэрдэггүй, зураглалын илэрхийлэл илүү нарийн болдог.

Хэлэлцүүлэг

Өмнө дурдсанчлан, булшны хэлбэр, чимэглэл нь зөвхөн бүс нутгийн ялгаатай байдлаас гадна, цаг хугацааны хувьслын явцад байнга өөрчлөгдөж байдгийг харж болно. Түүнчлэн, амьд хүмүүсийн харж чадахгүй газар доор бүтээгдсэн энэхүү байгууламж нь өөрийгөө тусгаарласан, “өөрөө өөрийгөө хангах” архитектур, урлагийн хэлбэр бөгөөд амьдралын ердийн архитекторын орчноос сайн дураараа тусгаарлагдсан байдаг. Хэдийгээр түүний загвар, чимэглэл нь зарим нэгэн нийтлэг соёл эсвэл урлагийн урсгалын нөлөөг тусгасан байдаг ч, зохион бүтээгчид болон чимэглэгчид газар дээрх байгууламжуудыг зохион бүтээхтэй ижил аргаар бусад булшнаас “эш татах” боломжгүй юм. Үүнээс гадна, нас барагсад өөрсдийн булшны талаар онцгой захиалга өгөх боломжтой бөгөөд амьд гэр бүлийн гишүүд ч мөн өөрсдийн сэтгэл хөдлөл, эх үрсийн үнэнч сэтгэлийг илэрхийлэх зорилгоор онцгой дүрслэл, эсвэл эд зүйлс ашиглаж болно. Дээрх болон бусад хүчин зүйлсийн улмаас, ямар ч хоёр язгууртны булшны агуулга, чимэглэл бүрэн ижил байхгүй бөгөөд гэр бүлийн булшны орчинд ойрхон байрласан ч гэсэн тэр боломжгүй юм.

Дүгнэлт

Сяньбичуудын ханын зургийн урлагийн амжилт нь дараах үндсэн шинж чанаруудаар тодорхойлогддог. Үүнд:

1. Сяньбичуудын ханын зургийн зохиомж нь үйл явдлын нарийн тооцолтын өгүүлэмжтэй байна. Энгийн зан үйл, амьдралын дүрслэл нь шашны агуулга, итгэл үнэмшилтэй уялдсан онцлогтай.
2. Тосоор найруулсан өнгөний найрлагын шинэлэг хэрэглээ нь өнгөний тод илэрхийлэлд шийдвэрлэх үйлдэл үзүүлж байна. Энэ нь Сяньби урлагийн шинэчлэл, ахиц дэвшлийг харуулдаг.

3. Шюй Шяньшию болон Лөү Рүй бунхны ханын зураг нь Сяньби угсаатны нэгдэл, соёлын солилцоог илтгэсэн түүхэн ба соёлын ач холбогдолтой юм. Мөн урлагийн өндөр үнэлэмж, түүхэн судалгаанд чухал эх сурвалж болсоор иржээ.
4. Эдгээр дүрслэл нь хожмын үеийн уран зургийн хөгжилд суурь болж, тогтвортой нөлөө үзүүлсэн байна.
5. Сяньбичуудын ханын зургийн урлаг нь зохиомж, агуулга, өнгөний илэрхийллийн хувьд шинэлэг арга барил, соёлын уялдаа холбоог бий болгосон. Бүтээлүүд нь түүхэн судалгааны ихээхэн үнэ цэнтэйгээс гадна, уран зурагт шинэ чиглэл нээсэн “Эрчимт хөдөлгөөнт урлаг” хэмээн тодорхойлж болно.

Ашигласан материалын жагсаалт

- Батсайхан, Ц. 2017. *Өнгө судлал. Урлахүйн чуулган-1*. Улаанбаатар.
- Батсайхан, Ц. 2020. *Монголчуудын эрхэм өнгө зохирол*. Улаанбаатар.
- Батчулуун, Л. 2018. *Монголын дүрслэх урлагийн нэвтэрхий толь*. Улаанбаатар.
- Ван Ванфу. 2016. *Умард Чи улсын Шюй Шяньшию бунхны ханын зургийн хамгаалалт, сэргээн засварлах судалгаа*. Бээжин: Соёлын өвийн хэвлэлийн хороо.
- Гэрэлбадрах, Ж. 2002. *Монголын нутаг дэвсгэр, хил хязгаарын түүх*. Улаанбаатар.
- Жэн Янь. 2013. *Нас барсан хүний маск. Хань-Тан улсын үеийн булшны урлагийн судалгаа*. Бээжин: Бээжин хэвлэлийн газар.
- Ли Яньшөү. 1974. *Умард Төрийн түүх. 97-р боть. Баруун хязгаарын тэмдэглэл*. Бээжин: Дундадын ном хэвлэлийн хороо.
- Лүө Шипин. 2004. *Тайван дахь Умард Чи улсын Шюй Шяньшию бунхны ханын зургийн Баруун хязгаарын нөлөөний тухай тэмдэглэл*. Гуанжөү: Жуншань их сургуулийн хэвлэлийн хороо.
- Лю Юэ. 2024. *Уран зургийн өнгөний хэлний шинжилгээ*. Чэндү: Сычуань үндэстний хэвлэлийн хороо.
- Сунь Ужүнь. 2012. “Умард төр, Суй, Тан улсын үеийн Хятад руу нүүн ирсэн Согдчуудын бунхны дүрслэлийн соёл, гоо зүйн судалгаа.” Ph.D дисс., Баруун хойд их сургууль.
- Ү Хун. 2010. *Мөнх бусын орны урлаг-Хятадын эртний бунхны өргөн хүрээний судалгаа*. Бээжин: Амьдрал-Унших-Шинэ мэдлэг Сан Лен номын дэлгүүр.

Хавсралт




Зураг 1. а Шюй Шяньшю бунхны ханын өнгөт зураг. VI зуун. БНХАУ-ын Шяньши мужийн Тайюань дахь умард Чи улсын ханын зургийн музей. Б.Хүчит 2024.



Зураг 1. б Шюй Шяньшю бунхны ханын зураасан зураг. Б.Хүчит 2025.




Зураг 2. а Лөү Рүй бунхны баруун ханын өнгөт зураг. Умард Чи улсын Дунан ван Лөү Рүйгийн бунхан 2006. Б.Хүчит 2025.



Зураг 2. б Лөү Рүй бунхны баруун ханын зураасан зураг. Умард Чи улсын Дунан ван Лөү Рүйгийн бунхан 2006. Б.Хүчит 2025.



Зураг 3. а Лөү Рүй бунхны зүүн ханын өнгөт зураг. Умард Чи улсын Дунан ван Лөү Рүйгийн бунхан 2006. Б.Хүчит 2025.



Зураг 3. б Лөү Рүй бунхны зүүн ханын зураасан зураг. Б.Хүчит 2025.